



● СТАРТ АП
ТӨСЛҮҮД
2019 ОН



ТӨСЛИЙН НЭР: КОМПОЗИТ МАТЕРИАЛААР УС ЦЭВЭРШҮҮЛЭХ

Төслийн удирдагч: Дэд профессор Д.Хасбаатар
ХШУИС, Хими, биологийн инженерчлэлийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

Манай төсөл нь иргэдийг эрүүл цэвэр усаар хангаж эрүүл монгол иргэдийг бий болгох зорилготой. "Aquafili+" нь хэрэглээний усыг цэвэрлэх зориулалттай шууд аягандаа дүрж хэрэглэх болон усны хоолойд байршуулах 2 төрлийн бүтээгдэхүүн санал болгож байгаа ба энэхүү бүтээгдэхүүн нь усны бактери, хлор болон эзвийг цэвэрлэхээс гадна хатуулийг багасгах үйлдвэрлэлийн зориулалттай төсөл юм. Монгол улсын их сургуулийн лаборатори-д үйлдвэрлэл нь явагдана. Манай бүтээгдэхүүн өдөр тутам авч явах болон ахуйн хэрэглээнд зориулагдсан 2 төрөлтэй.


Манай төслийг хэрэгжүүлснээр хэрэглэгчдийн цаг хугацаа (дэлгүүр орж цэвэр ус авах, ус буцалгаад хөрөхийг хүлээх) болон санхүүгийн хэмнэлт болон гэрийн цоргоноосоо цэвэршүүлсэн усыг шууд ууж хэрэглэх боломж гарах ба энэ нь хэрэглэгчдийн хэрэглээг хялбарчилж өгч байгаад оршино.

Ус цэвэршүүлэгч бодис бэлтгэн нийлүүлэх байгууллага, тоног төхөөрөмж, түүхий эд материал бэлтгэн нийлүүлэгчид манай төсөлтэй хамтран ажиллана. Бид МУИС инновац төслийн шалгаруулалтад орох, Төрийн банкны патент барьцаалж эзэл авах, Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих төсөлд оролцох зэргээр төслийнхөө Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг авах боломжтой.



ЗОРИЛГО:

Монгол орны түүхий эдийг ашиглан үндэсний бренд бүтээгдэхүүн шинээр бий болгох.



Судалгааны багийн гишүүд:

- А.Ариунжаргал ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
- А.Женнифер ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
- А. Мөнх-Уйлс ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
- Г. Хонгорзул БС, 3-р түвшин
- Б. Бүрнээбаяр БС, 3-р түвшин
- Б. Ичинхорлоо БС, 3-р түвшин

Холбоо барих мэдээлэл

МУИС, Хичээлийн төв байр-236

77307730 - 1198

d_khasbaatar@num.edu.mn



ТӨСЛИЙН НЭР: SOYBUCKTORN-ШАР БУУРЦАГ ЧАЦАРГАНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ПРОБИОТИК УНДАА

Төслийн удирдагч: Профессор Б. Батжаргал
ШУС, БУС, Биологийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

GRAS буюу эрүүл мэндэд хор хөнөөлгүй, аюул багатай шинж чанартай сүүн хүчлийн бактерийн биологийн идэвхтэй нэгдлүүд, сүүн хүчлийн бактерийн практик ач холбогдол болон үйлдвэрлэлд ашиглах боломжийн талаарх судалгаанууд өргөн хийгдэж байна. Эдгээрт амьд бичил биетний нэмэгдал тэжээл болох пребиотикууд болон пробиотик микроорганизмыг аль алыныг нь агуулсан синбиотик хүнсний бүтээгдэхүүний судалгаа мөн хамрагдаж байгаа юм.

Бид пробиотик идэвхтэй, протеолитик идэвхтэй, антиоксидант идэвхтэй, β -глюцидаза болон α -галактозидаза энзимийн идэвхтэй *L.plantarum* бактерийн хөрөнгө ба пребиотик тэжээл болох шар буурцгийн сүүг хослуулан синбиотик бүтээгдэхүүн гарган авах арга боловсруулсан.



Эх хөрөнгийн биологийн идэвхийн нөлөөгөөр зохицуулах үйлчилгээтэй хүнсний төрөлд багтаж улмаар чацаргана жимс нэмснээр амт чанарыг сайжруулан "Шар буурцаг чацарганы эрүүл мэндийн пробиотик ундаа" хэмээн нэрлэсэн.



Судалгааны багийн гишүүд:

- М.Батмөнх ШУС, Биологийн тэнхим, Магистр
- Ц.Манчир ШУС, Биологийн тэнхим, Магистрант
- Л. Мөнхтүвшин ШУС, Биологийн тэнхим, 3-р түвшин
- Д. Энхжин ШУС, Биологийн тэнхим, 4-р түвшин
- Ц.Саранцэцэг ШУС, Биологийн тэнхим, 4-р түвшин
- О. Мөнхнасан БС, 4-р түвшин
- М.Зулсар БС, 3-р түвшин
- Б. Мишээл ОУХНУС, ОУХТ, 3-р түвшин

Холбоо барих мэдээлэл

МУИС, ШУС, БУС, Биологийн тэнхим

77307730 – 2413

batjargal@num.edu.mn





ТӨСЛИЙН НЭР: “МАХҮТЕСТ” МАХ ЯЛГАН ТОДОРХОЙЛОХ ЦОМОГ

Төслийн удирдагч: Дэд профессор Д.Лхагвасүрэн
ШУС, БУС, Биологийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

Стратегий хүнс гэдэг нь Монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, малын сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны ус зэрэг болно. Тиймээс бид уг оношлуурын тусламжтай монголчуудын хүнсний хэрэглээний стратегийн чухал нэрийн бүтээгдэхүүн махан бүтээгдэхүүний түүний гарал үүслийг ялган тодорхойлох, баталгаажуулах боломжтой юм.

Молекул биологийн аргад суурилсан энэхүү оношлуур нь махны дээжийг 98%-ийн нарийвчлалтай өвөрмөцөөр таних учраас хүнсний худалдааны мах махан бүтээгдэхүүний гарлыг баталгаажуулах, шалгахад чухал үүрэгтэй хүртээмжтэй хялбар бүтээгдэхүүн бөгөөд энэ нь нийгэмд зайлшгүй шаардлагатай байгаа шинжлэх ухаанд суурилсан нарийн арга зүйг ашигласан инновацийн бүтээгдэхүүн болно.



Молекул биологийн аргад суурилсан энэхүү оношлуур нь махны дээжийг 98%-ийн нарийвчлалтай өвөрмөцөөр таних учраас хүнсний худалдааны мах махан бүтээгдэхүүний гарлыг баталгаажуулах, шалгахад чухал үүрэгтэй. Уг зорилгын хүрээнд дээрх хонь болон ямааны эсрэг төрөгчдийн эсрэг, поликлонт эсрэг бие ялган авч, турган оношлуур бэлтгэн зах зээлд навтрүүлнэ.



Судалгааны багийн гишүүд:

Ц.Хишигжаргал ШУС, БУС, Биологийн тэнхим, Магистрант
Д.Нандинцэцэг ШУС, БУС, Биологийн тэнхим, 4-р түвшин
Б.Оюунсүэд ШУС, БУС, Биологийн тэнхим, 4-р түвшин
Ц.Номин ХШУИС, ХБИТ, Магистрант
М.Лхагвасүрэн ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
Т.Нямцэцэг ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
Б. Билгүүн БС, 4-р түвшин

Холбоо барих мэдээлэл

МУИС, Хичээлийн байр 2-213В

☎ 77307730 – 2419

✉ lkhagvasuren.d@num.edu.mn



ТӨСЛИЙН НЭР: SOLAR HOT WATER

Төслийн удирдагч: Магистр Б.Онон, Доктор. Э.Пүрэвдалай
ХШУИС, Электроник, холбооны инженерчлэлийн тэнхим


ТАНИЛЦУУЛГА:

Халуун усны зайлшгүй хэрэглээтэй газрууд нь хүүхдийн зуслан, амралтын газрууд, жуулчны баазууд, жижиг дунд үйлдвэрийн газрууд, гэр хороолол мөн лагерийн сууцнууд зэрэг байна. Усыг халаахад цахилгаан халаагуур эсвэл нүүрс, түлш ашиглаж байгаа нь урсгал зардал ихтэйн дээр байгаль орчинд сөрөг нөлөөтэй. Үүнийг гадны орнууд нарны дулааны коллектор ашиглах байдлаар хялбархан шийдэж байна. Нарны дулааны коллекторыг 1940 оноос хойш дэлхий нийтээр өргөн ашиглах болсон бөгөөд өдгөө хавтгай, вакуум, цилиндр, парабол коллектор гээд маш олон төрлүүд болон өргөжин хөгжсөн. Нарны дулааны коллектор нь нарны энергийг шууд дулааны энергид хувиргадаг төхөөрөмж юм. Манай орон нь нарны нөөц сайтай, чийгшил бага, жилийн 365 хоногийн 300 орчим хоногт нь үүлгүй цэлмэг байдаг гээд нарны төхөөрөмжийг ашиглахад нэн тохиромжтой бүсэд тооцогддог. Манай төслийн зорилго нь онцгой хэрэглээнд тохирсон хямд үнэтэй нарны хавтгай коллекторыг Монголдоо үйлдвэрлэх юм.



БИДНИЙ ДАВУУ ТАЛУУД:

- Төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг хэмжих хэмжилтийн лабораторитой
- Мэргэшсэн багш, боловсон хүчинтэй
- Олон жилийн судалгааны ажлын үр дүн, олон улсын нэр хүнд бүхий шинжлэх ухааны сэтгүүлүүдэд хэвлэгдсэн ажлуудтай
- Энэ чиглэлээр сурч боловсорсон оюутнуудыг багтаа авч ажиллуулах боломжтой
- Угсралт, туршилт хийх боломж орон зай бүхий лабораторийн байртай
- Хамжилтийн багаж хэрэгсэлтэй
- Зарим нэг угсралтад зориулсан гагнуурын багажтай



Судалгааны багийн гишүүд:

- Б. Адъяабазар ХШУИС, ЭХИТ, СЭХ, 4-р түвшин
- Б. Анударь ХШУИС, ЭХИТ, СЭХ, 4-р түвшин
- Ц. Түвшинжаргал ХШУИС, ЭХИТ, СЭХ, 4-р түвшин
- А. Сэр-Од ХШУИС, ЭХИТ, СЭХ, 4-р түвшин
- Б. Балжинпүрэв ХШУИС, ЭХИТ, СЭХ, 4-р түвшин
- А. Нурбулан ХШУИС, ЭХИТ, СЭХ, 3-р түвшин
- Б.Батдэлгэр БС, Банк, 4 түвшин

Холбоо барих мэдээлэл

МУИС, Хичээлийн байр 3-121

77307730 – 3344

bayasgalanonon@gmail.com ,
purvee47@yahoo.com

ТӨСЛИЙН НЭР: THE SCIENTIFIC TOUR OF NUM

Төслийн удирдагч: Доктор Ч.Сономдагва
ХШУИС, Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

Scientific Tour of NUM төсөл нь байгалийн шинжлэх ухаанд дуртай, үүргэвчтэй аялал хийдэг хүн бүхэнд зориулагдсан бөгөөд МУИС-ийн оюутнуудтай хамтдаа Монгол орноор тодорхой маршрутын дагуу аялах ба мөн үүний зэрэгцээ байгаль орчны талаар өргөн хүрээний мэдлэгтэй болоод зогсохгүй улсдаа хувь нэмрээ оруулж буй үйлдвэр, уурхайтай танилцаж явах юм. МУИС-ийн ХХШУИС-ийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимд суралцаж буй оюутнууд нь хээрийн дадлага ажлаар дээрх дурдсан зүйлсийг хийдэг бөгөөд мөн агвар, хөрс, ус, ургамлаас дээж авах, хэмжих, боловсруулах гэх мэт зүйлсийг хийдэг нь аялагчдад шинжлэх ухааны

мэдлэгийг давхар олгох юм. Төслийн давуу тал нь бид амралтын газар, баазад байрлахгүй майхантай аялал хийх бөгөөд мөн хоол цайгаа өөрсдөө хийх учраас аялагчдад маш их хэмнэлтийг бий болгоно. Мөн оюутан залуус өөрсдөө хөтөч хийх ба энэ нь залуус хэлний мэдлэгээ дээшлүүлэх боломж болж байна.

Монгол улсад жилд дунджаар 440.0 аялагчид ирдэг бөгөөд тэдгээрийн ердөө 0.0001%-г энэхүү аялалд хамрагдвал 44 хүн болох ба энэ нь жилийн хугацаанд хангалттай гэж үзэж байна. 1 өдрийн аялал нь 61\$ бөгөөд 21 хоногийн аялал нь 1281\$ болж байна ингэснээрээ аялагчид маань нийт зуучлалын байгууллагаар дамжуулан аялснаас даруй 1491\$ хэмнэж чадаж байна.



Scientific Tour of NUM төсөл нь байгалийн шинжлэх ухаанд дуртай, үүргэвчтэй аялал хийдэг хүн бүхэнд зориулагдсан.



Судалгааны багийн гишүүд:

Г. Уламбаяр ХШУИС, ХБООИТ, магистрант
А. Ариундалгэр ХШУИС, ХБООИТ, 4-р түвшин
С. Сувд-Эрдэнэ ХШУИС, ХБООИТ, 4-р түвшин
Б. Наранзаяа ХШУИС, ХМТ, магистрант

Холбоо барих мэдээлэл

МУИС, Хичээлийн байр 3А-218

75754400, 77307730-2105

ch_sonomdagva@num.edu.mn





ТӨСЛИЙН НЭР: “ЭНЕРГИЙН ИННОВАЦ”

Төслийн удирдагч: Профессор Б.Энхсаруул
ШУС, БУС, Химийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

Улаанбаатар хотын агаарын бохирдлын гол шалтгаан нь түүхий нүүрсний хэрэглээ юм. Агаарын бохирдлыг нүүрсэнд агуулагдах азот, хүхэр ба хүнд металлуудаас үүсэх төрөл бүрийн дагдэмхий хортой нэгдлүүд, мөн дутуу шаталтын улмаас үүсэх органик нэгдлүүд бүрдүүлж байдаг. Манай улсад хатуу түлшний эх үүсвэрээр ихэвчлэн залуу хүрэн нүүрс (Багануур, Шивээ-овоо, Налайх гэх мэт)-ийг хэрэглэдэг ба энэ төрлийн түүхий эд нь үнс, чийгийн агуулга өндөртэй учир түүнийг хэрэглэх, боловсруулах үед хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюултай, хортой хог хаягдлыг асар их хэмжээтэй үүсгэдэг байна.

Манай орны хувьд 163 тэрбум тонн нүүрсний нөөцтэй ба нүүрсийг байгалийн хийд хувиргах үр дүнтэй аргаар боловсруулж, ахуйн дулаан ба эрчим хүчний эх үүсвэрийн тодорхой хувийг нийлэг байгалийн хийгээр орлуулан хорт утаанаас сэргийлэх, агаарын бохирдлыг бууруулах, эдийн засгийн үр ашигтай аргыг хэрэглээнд нэвтрүүлэх бүрэн боломжтой юм.



Бид Монгол орны байгалийн нөөцөд тулгуурлан цэвэр энергийн технологи бий болгох хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр судалгааны ажлаа гүйцэтгэж байна.



Судалгааны багийн гишүүд:

Б.Буян-Өлзий ШУС, Хими / Магистрант/
Б.Ариунжаргал ШУС, Хими / Магистрант/
Х.Барсболд ШУС, Хими /Магистрант/
Б.Нямсүрэн ШУС, Хими /Магистрант/
Т.Баасанжаргал ШУС, Хими /Магистрант/
А.Нямсүрэн ШУС, Хими /4-р түвшин/
Г.Сувданчимэг ШУС, Хими /4-р түвшин/
Б.Отгонномин-Эрдэнэ БС, Менежмент /3-р түвшин/
Б.Мөнхтуяа БС, Менежмент /3-р түвшин/



Холбоо барих мэдээлэл

МУИС, ШУС, БУС, Химийн тэнхим

77307730 - 2469

enkhsaruul_b@num.edu.mn





ТӨСЛИЙН НЭР: МОНГОЛ ОРНЫ АКТИНОМИЦЕТЭЭС ХООЛОЙН МАХНЫ ҮРЭВСЛИЙН ЭСРЭГ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ЭМИЙН БЭЛДМЭЛ ГАРГАН АВАХ

Төслийн удирдагч: Дэд профессор Б.Даваапүрэв
ХШУИС, Хими, биологийн инженерчлэлийн тэнхим

ТАНИЛЦУУЛГА:

Дэлхий дээр мэдэгдэж буй 10,000 гаруй антибиотикийн 70 гаруй хувийг актиномицетээс гарган авсан байдаг бөгөөд бидний сайн мэдэх антибиотикүүд болох эритромицин, канамицин, гентамицин, тетрациклин, стрептомицин зэргийг актиномицетээс гарган авчээ. Актиномицет нь биологийн идэвхт нэгдлийг ихээр ялгаруулдаг микроорганизм юм. Хоолойн махыг анагаахын шинжлэх ухаанд гүйлсэн булчирхайн үрэвсэл, тонзолит, ангин гэх мэтчилэн янз бүрээр нэрлэдэг. Амны хөндийн залгиурын хажуу хананд байрладаг хос булчирхай үрэвсэхийг гүйлсэн булчирхайн үрэвсэл буюу хоолойн мах гэнэ. Уг өвчний эмчилгээ оношилгооны асуудал өнөөдрийг хүртэл дэлхийн эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал хэвээр байна.

Бид хоолойн махыг үрэвсүүлэгч бета-цус задлагч А бүлгийн стрептококк бактерийн устгах үйлчилгээтэй байгалийн гаралтай бүтээгдэхүүн гарган авахаар зорьж байна. Ихэнх биологийн гаралтай бүтээгдэхүүнүүд ургамлаас гаргаж авсан байдаг. Гэвч ургамал нь байгаль дээр уур амьсгал, орчны нөлөөнөөс хамааралтай ургадаг бөгөөд нөөцийн хувьд эрсдэлтэй байдаг. Бидний төслийн бусдаас ялгарах хамгийн гол технологийн давуу тал бол ургамлын дотор амьдарч өөрийн үйл ажиллагаагаа явуулдаг актиномицет гэж нэрлэгдэх микроорганизоос биологийн идэвхт нэгдэл буюу хоёрдогч метаболит ялган авч, хоолойн махыг гол үрэвсүүлэгч бета-цус задлагч А бүлгийн стрептококк бактерийг устгах үйлчилгээтэй бүтээгдэхүүн гарган авахад оршино.



Актиномицет нь биологийн идэвхт нэгдлийг ихээр ялгаруулдаг микроорганизм юм.



Холбоо барих мэдээлэл

МУИС, ХШУИС, Хими, биологийн инженерчлэлийн тэнхим

75754400-3212

davaapurev@seas.num.edu.mn

Судалгааны багийн гишүүд:

Г. Намуунаа ХШУИС, ХБИТ, Магистрант
А.Ган-Эрдэнэ ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
М.Номуундарь ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
О.Ундармаа ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
Д.Өлзийбаяр ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
Д.Энхтуул ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
М.Бадмаараг ХШУИС, ХБИТ, 4-р түвшин
Ү.Батмагнай БС, Санхүүгийн тэнхим, 3-р түвшин
З.Бүрэнжаргал БС, Санхүүгийн тэнхим, 3-р түвшин

Төслийн удирдагч: Дэд профессор Н.Угтахбаяр
ХШУИС, Электроник, холбооны инженерчлэлийн тэнхим


ТАНИЛЦУУЛГА:

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн хохирлын хэмжээ 2019 оны эхний улиралд 2 их наяд доллар байгаа талаарх судалгааг Jupiter танилцуулсан нь энэ төрлийн гэмт хэрэг тасралтгүй өсөж буйг илтгэж байна. Бидний өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг нь цахим орчноос хамааралтай байгаа энэ үед хувь хүн, байгууллага нь өөрсдийн аюулгүй байдлаа хангах зайлшгүй шаардлагатай болж байна. МАБ-ын эрсдэлийн 50%-с илүү нь байгууллагын дотоод ажилчдын буруутай үйл ажиллагаанаас болсон байдаг талаар судалгааны байгууллагууд танилцуулж буй нь байгууллага ажилчиддаа МАБ-ын мэдлэг мэдээллийг үр дүнтэй, цаг алдалгүй хүргэх зайлшгүй шаардлага байгааг илтгэж байна.



УГ ТӨСЛИЙН НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ДАВУУ ТАЛ:

- Бүх нийтэд зориулсан нээлттэй мэдлэгийн санг бий болгоно.
- Бүх нийтийг МАБ-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулна.
- Дунд сургууль, их сургууль, хувь хүн зэрэгт зориулан ялгаатай контентууд бэлтгэн мэдлэгийг эмх цэгцтэй олгоно.
- Хувь хүн өөрийн аюулгүй байдлыг хангаснаар цахим орчинд гэр бүл, үр хүүхэд, найз нөхөд болон бусад хүрээллийн хүмүүсийг хамгаалах талаар ухагдахуунтай болно.
- МУИС-ийн нийгэмд үзүүлэх үйлчилгээний тоо нэгээр нэмэгдэнэ.



Судалгааны багийн гишүүд:

Ц.Амартүвшин ХШУИС, ЭХИТ, 4-р түвшин
Б.Баярболд ХШУИС, ЭХИТ, 4-р түвшин
Ж.Бямбажаргал ХШУИС, ЭХИТ, 4-р түвшин
Т.Нямжаргал ХШУИС, ЭХИТ, 4-р түвшин

Холбоо барих мэдээлэл

МУИС, ХШУИС, Электроник, холбооны инженерчлэлийн тэнхим

☎ 77307730 – 3333

✉ 16b1seas0574@stud.num.edu.mn